



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 04 сарын 24 өдөр

Дугаар А/482

Ховд

Улсын комисс байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4-ийн "а", Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, Засгийн газрын 2018 оны 317 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм"-ийн 3.1.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Ховд аймгийн Алтай, Зэрэг сумын нутаг дэвсгэрт "Богоч констракшн" ХХК-ний барьж гүйцэтгэсэн Замын хөдөлгөөний байнгын постын барилгын барилга угсралтын ажлыг хүлээн авах улсын комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Улсын комиссын  
дарга: Б.Баярсүх

- Аймгийн Газрын харилцаа, барилга хот  
байгуулалтын газрын дарга

Гишүүд: У.Пүрэвдорж

-Ховд цахилгаан түгээх Сүлжээ ХХК-ний  
ерөнхий инженер

С.Чанцал

-Мэргэжлийн хяналтын газрын Барилга  
техникийн хяналтын улсын байцаагч

Б.Түмэндэмбэрэл

-Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө  
оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн  
хэлтсийн барилга, газрын харилцааны  
асуудал хариуцсан мэргэжилтэн

Г.Ганжаргал

-Онцгой байдлын газрын гал түймрийн  
улсын байцаагч

Б.Тулгаа

-Цагдаагийн ерөнхий газрын Санхүү, аж  
ахуйн албаны барилга байгууламжийн  
хяналтын тасгийн барилгын ахлах  
инженер, цагдаагийн ахмад

Zax- A/482 Ch  
02 02390

- Н.Балжинням -Ховд аймаг дахь Цагдаагийн газрын замын цагдаагийн тасгийн дарга, Цагдаагийн хошууч
- Н.Равданпүрэв -Ховд аймаг дахь Цагдаагийн газрын аж ахуйн офицер, цагдаагийн ахмад
- С.Батдорж -Аймгийн архивын тасгийн дарга
- Б.Энхбаяр -Алтай сумын Засаг дарга
- Б.Октябрь -Зэрэг сумын Засаг дарга
- Б.Нямчулуун -Богоч констракшн ХХК-ний захирал

Нарийн бичгийн

дарга: Д.Тогтохбаяр -Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн мэргэжилтэн

2. Ховд аймгийн Алтай, Зэрэг сумын нутаг дэвсгэрт "Богоч констракшн" ХХК-ний барьж гүйцэтгэсэн Замын хөдөлгөөний байнгын постын барилгын барилга угсралтын ажлыг зураг, төсвийн дагуу шалгаж хянан баталгаажуулж шийдвэр гаргахыг улсын комиссын дарга /Б.Баярсүх/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ